



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн “Энх Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/49/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Ахлах аудитор: Ж.Бүжинханд Утас: 99177546 Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Цахим хаяг: Bujinkhandj@audit.gov.mn Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn
---	--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 53
танай _____ -ны № _____ -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
"ЭНХ-АЛТАЙ" ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
О.БИНДЭРЪЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Говь-Алтай аймгийн "Энх Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн "Энх Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020138

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,390,526.09	113,080,184.15
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,683,033.39	1,310,433.39
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,683,033.39	1,310,433.39
3121	Төгрөг	1,683,033.39	1,310,433.39
31213	Арилжааны банк дахь харилцах	1,683,033.39	1,310,433.39
33	АВЛАГА	118,939.00	94,081,700.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	118,939.00	-
335	Бусад авлага	-	94,081,700.00
3351	Байгууллагаас авах авлага	-	94,081,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,588,553.70	17,688,050.76
351	Түүхий эд материал	6,898,222.40	9,587,065.56
35130	Эм боох материал	6,898,222.40	9,587,065.56
354	Хангамжийн материал	8,690,331.30	8,100,985.20
35410	Бичиг хэргийн материал	1,074,800.00	882,310.00
35420	Аж ахуйн материал	7,030,531.30	7,218,675.20
35430	Сэлбэг хэрэгсэл	585,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	28,293,998.75	38,522,117.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	28,293,998.75	38,522,117.97
392	Биет хөрөнгө	28,293,998.75	38,522,117.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	6,800,000.00	26,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,480,555.40)	(9,966,666.88)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,113,136.13	50,481,871.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	(32,633,120.74)	(31,735,207.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	12,696,315.00	11,738,878.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,201,776.24)	(8,796,757.20)
39301	Програм хангамж	192,500.00	192,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(192,500.00)	(192,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	45,684,524.84	151,602,302.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	160,410.00	41,233,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	160,410.00	41,233,500.00
413	Өглөг	160,410.00	41,233,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	160,410.00	-
4136	Бусад өглөг	-	41,233,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	41,233,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	45,524,114.84	110,368,802.12
51	Засгийн газрын хувь оролцоо	45,524,114.84	110,368,802.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	24,905,986.42	24,905,986.42
51101	Өмч: - төрийн	24,905,986.42	24,905,986.42
512	Хуримтлагдсан үр дүн	19,894,408.42	84,739,095.70
51210	Өмнөх үеийн үр дүн	19,894,408.42	19,894,408.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	64,844,687.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	723,720.00	723,720.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	45,684,524.84	151,602,302.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	208,135,020.80	594,087,761.52
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,702,090.80	126,835,976.52
120	Нийтлэг татварын бус орлого	8,702,090.80	126,835,976.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,702,090.80	126,060,976.52

Говь-Алтай аймгийн "Энх Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,932,620.00	17,580,205.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,769,470.80	126,060,976.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,002,650.00	297,615,785.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	174,362,900.00	170,411,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	25,070,030.00	280,035,580.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,070,030.00	280,035,580.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	191,169,561.79	529,243,074.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	191,169,561.79	529,243,074.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,485,761.79	508,243,074.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	132,585,807.00	198,485,791.00
210101	Үндсэн цалин	132,585,807.00	198,485,791.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,356,340.46	22,662,631.00
210201	Тэтгэврийн даатгал	4,543,402.20	16,967,760.00
210202	Тэтгэмжийн даатгал	282,016.00	1,020,128.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	222,254.00	816,105.00
210204	Ажилгүйдлийн даатгал	50,796.00	188,257.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,257,872.26	3,670,381.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,016,152.00	3,074,686.00
210301	Гэрэл, цахилгаан	1,935,424.00	737,900.00
210302	Түлш, халаалт	-	159,160.00
210303	Цэвэр, бохир ус	1,080,728.00	2,177,626.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,544,930.97	12,014,992.30
210401	Бичиг хэрэг	2,213,085.00	1,562,150.00
210402	Тээвэр, шатахуун	3,354,420.00	2,854,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	689,790.00	1,302,690.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	75,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,212,635.97	6,205,752.30
2105	Нормативт зардал	15,031,852.76	250,596,717.16
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,031,852.76	250,101,717.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	495,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,975,500.00	5,716,025.00
210604	Урсгал засвар	8,975,500.00	5,716,025.00
2107	Томилолт, зочны зардал	860,500.00	127,600.00
210702	Дотоод албан томилолт	860,500.00	127,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,986,688.00	3,343,751.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,486,000.00	3,161,201.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	131,400.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	41,888.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00

Говь-Алтай аймгийн "Энх Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	89,400.00	86,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,127,990.60	12,220,880.78
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	702,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,425,990.60	12,220,880.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,683,800.00	21,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,683,800.00	21,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,683,800.00	16,600,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	16,965,459.01	64,844,687.28
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	16,965,459.01	64,844,687.28

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,905,986.42	723,720.00	-5,715,612.22	19,914,094.20
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,905,986.42	723,720.00	-5,715,612.22	19,914,094.20
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,644,561.63	8,644,561.63
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,905,986.42	723,720.00	19,894,408.42	45,524,114.84
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,905,986.42	723,720.00	19,894,408.42	45,524,114.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	24,905,986.42	723,720.00	19,894,408.42	45,524,114.84
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	64,844,687.28	64,844,687.28
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	24,905,986.42	723,720.00	84,739,095.70	110,368,802.12

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	202,365,550.00	373,945,085.00

**Говь-Алтай аймгийн “Энх Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,932,620.00	17,580,205.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,932,620.00	17,580,205.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,932,620.00	17,580,205.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,932,620.00	17,580,205.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	202,365,550.00	373,945,085.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	174,362,900.00	170,411,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	25,070,030.00	185,953,880.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,070,030.00	185,953,880.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	189,595,291.46	372,098,685.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	189,595,291.46	372,098,685.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	189,595,291.46	356,698,685.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	189,595,291.46	356,698,685.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	189,595,291.46	356,698,685.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	15,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	15,400,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	4,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	11,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,770,258.54	1,846,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,106,700.00	2,219,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,106,700.00	2,219,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,106,700.00	2,219,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,106,700.00	2,219,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,106,700.00)	(2,219,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,663,558.54	(372,600.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,474.85	1,683,033.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,683,033.39	1,310,433.39

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн “Энх Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Санчирмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн “Энх Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу Говь-Алтай аймгийн “Энх Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Хүний хөгжлийг дэмжих зорилгоор нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг нотолгоо үр дүнд суурилан тэгш хүртээмжтэй чанартай үзүүлэн эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн “Энх Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 191.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 529.2 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр тогтоогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн “Энх Алтай” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3 дахин буюу 105.9 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Авлага дансны үлдэгдэл 52.5 сая төгрөг болж өссөн нь гүйцэтгэлээр санхүүжих нийгмийн даатгалын хэлтсээс авах авлагатай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 17.7 сая төгрөг болж 2.1 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 162.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, хандиваар 105.8 сая төгрөгийн хүлээн авч үйл ажиллагаандаа 266.4 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 38.5 сая төгрөг болж 10.2 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2.2 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 20.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл шилжүүлэн авч 0.2 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой.

Өглөг дансны үлдэгдэл 41.2 сая төгрөг болж өссөн нь байгууллагад төлөх өглөгтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 110.4 сая төгрөг болж 64.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 3 дахин буюу 385.9 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилтийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 84.7 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

И-баримтгүй 19.6 сая төгрөгийн гүйлгээ хийснээс 17.8 сая төгрөгийг аудитын явцад нөхөн шивүүлсэн нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 1 заалт зөрчил арилгах албан шаардлага хүргүүлж шийдвэр хангагдсан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар:

- Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Авлага, өглөгийн барагдуулалтыг үзэх
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 19.4 сая төгрөгийн алдааг залруулж, 4.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Нэр бүхий 7 компаниас 17.8 сая төгрөгийн худалдан авалтын и-баримтыг гаргуулаагүй байсныг аудитын явцад нөхөж шивүүлсэн. Татварын тодорхойлолтын 1.6 сая төгрөгийн зөрүүг аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Тендерт шалгараагүй иргэн ААНБ-аас 2.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

И-баримтгүй 1.8 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14

хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн тайлан болон татвар тодорхойлолт 0.6 сая төгрөгийн илүү, 0.2 сая төгрөгийн дутуу зөрүүтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалттай нийцээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим системд 25 мэдээлэл мэдээлэхээс 14 мэдээлэл хугацаа хоцроон мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ. 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалтыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говь-Алтай аймгийн "Энх Алтай" өрхийн эрүүл мэндийн төвийн	4	24.4	2	19.4	0	0	3	4.9	1	0